



**ОРХОН АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ**

2015 оны 01 сарын 29 өдөр

Дугаар 09

Эрдэнэт

Журам шинэчлэн батлах тухай

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. "Аймгийн ИТХ-ын шагналын журам"-ыг хавсралтын ёсоор шинэчлэн баталсугай.
2. Аймгийн ИТХ-ын шагналын журмыг олон нийтэд мэдээлэх, сурталчлах ажлыг зохион байгуулахыг Аймгийн ИТХ-ын дарга Б.Мягмарсүрэнд даалгасугай.
3. Энэхүү тогтоол гарсантай холбогдуулан Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2013 оны 04 дүгээр сарын 10-ны өдрийн 45 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА

Б.МЯГМАРСҮРЭН



АЙМГИЙН ИТХ-ЫН ШАГНАЛЫН ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.Энэхүү журмын зорилго нь Аймгийн ИТХ-ын байгууллагын шагнал, шагналд нэр дэвшүүлэх, хүлээн авч судлах, шийдвэрлэх, гардуулах, үнэмлэхийг нөхөн олгохтой холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

2.Аймгийн ИТХ нь өөрийн шагналтай, шагналын мөнгөн сантай байна.

3.Хурлын байгууллагын шагналын Цом, Медалийн загвар, тодорхойлолт нь Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн хуралдаанаар батлагдсан байна.

4.Аймгийн ИТХ-ын байгууллагын шагналаар аймаг, хотынхоо хөгжил цэцэглэлт, хүн ардынхаа амьдрал ахуйг дээшлүүлэх, эрүүл мэндийг сахин хамгаалах, мэдлэг боловсролыг дээшлүүлэх, шинээр ажлын байр бий болгох, үйлдвэрлэл, үйлчилгээг нэмэгдүүлэх, шинэ техник технологи үйлдвэрлэлд нэвтрүүлэх, бүтээмж, инновацийг хөгжүүлэх,хот байгуулалт, тохижилт, нутгийн өөрөө удирдах ёсны болон төр захиргааны ажилдаа хөдөлмөрийн амжилт гаргаж, бодит хувь нэмэр оруулсан олон түмний дунд нэр хүндтэй иргэнийг шагнана.

5.Аймаг, орон нутгийн бүтээн байгуулалтад гар бие оролцож ажлын өндөр амжилт гаргасан гадаадын иргэнийг Аймгийн ИТХ-ын шагналаар шагнаж болно.

6.Аймаг орон нутгийн бүтээн байгуулалтад олон жил идэвх зүтгэл, үр бүтээлтэй ажиллаж, ажлын өндөр амжилт гаргасан хүмүүсийг аймгийн ИТХ-ын шагналаар шагнаж урамшуулах ажлыг тухай бүр зохион байгуулна.

7.Аймаг хот, салбар,байгууллага байгуулагдсаны тэгш ойг тохиолдуулан тухайн салбар, байгууллагын тэргүүний ажилтан хүмүүсийг Аймгийн ИТХ-ын шагналаар шагнаж болно.

8.Аймгийн ИТХ-ын шагналаар байгууллагын хурал, зөвлөгөөнийг тохиолдуулан шагнахгүй.

9.Аймгийн ИТХ-ын шагналаар өмнө нь шагнуулсан хүн дахин шагналд тодорхойлогдсон бол өөр шагналаар буюу шагналыг өгсүүлэх зарчмыг баримтална.

10.Онцгой тохиолдолд аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчид журамд зааснаас өөрөөр шийдвэрлэж болно.

Хоёр.Аймгийн ИТХ-ын шагнал

2.1. Шагналын төрөл

2.1.1.Аймгийн ИТХ-ын шагнал нь Аймгийн ИТХ, Засаг даргын хамтарсан шагнал

2.1.2.Аймгийн ИТХ-ын шагнал гэсэн хэлбэртэй байна.

2.2.Аймгийн ИТХ, Засаг даргын хамтарсан шагнал

2.2.1.“Орхон аймгийн Хүндэт иргэн” цол тэмдэг нь аймгийн ИТХ, Засаг даргын хамтарсан шагнал байна.

2.2.2. Дээрх шагналаар шагнах асуудлыг тусгай журмаар зохицуулна.

2.3 Аймгийн ИТХ нь дор дурьдсан шагналтай байна.

2.3.1. “Цагаан арслан” цом

2.3.2. “Иргэний төлөө” медаль

2.3.3. “Орхон аймгийн оны Алдартан” Хүндэт самбар

2.3.4. Аймгийн ИТХ-ын “Хүндэт жуух бичиг”

2.3.5. Аймгийн ИТХ-ын шагнал нь дагалдах мөнгөн шагналтай байна.

2.4 Аймгийн ИТХ-ын шагналын тодорхойлолт, дагалдах мөнгөн шагнал

2.4.1. Аймгийн ИТХ-ын дээд шагнал нь “Цагаан арслан цом” байна.

2.4.1.1. Нутгийн удирдлагын байгууллага, орон нутгийн эдийн засаг, нийгэм, оюун санааны хөгжилд шинэ жишгийг бий болгосон, инноваци, шинэ техник технологи, ноу-хау нэвтрүүлэх, нутагшуулах, технологи дамжуулах замаар өндөр технологи шингэсэн шинэ бүтээгдэхүүн, ажил үйлчилгээг нэвтрүүлж орон нутгийн хөгжилд бодит хувь нэмэр оруулсан байгууллага, иргэнийг шагнана.

2.4.1.2. Хурлын дээд шагнал “Цагаан арслан” цомоор жилд нэг удаа сар шинийн баярыг тохиолдуулан шагнана.

2.4.1.3. Хурлын дээд шагнал “Цагаан арслан” цом нь Хүндэт өргөмжлөлтэй байна.

2.4.2. Аймгийн ИТХ-ын шагнал “Иргэний төлөө медаль”-иар тус аймагт 10-аас доошгүй жил ажиллаж, хөдөлмөрийн тогтвортой амжилт гарган Эрдэнэт хот, Орхон аймгийн бүтээн байгуулалтад бодит хувь нэмэр оруулсан хүнийг шагнана.

2.4.2.1. “Иргэний төлөө” медаль нь үнэмлэх, 100.000 төгрөгийн дагалдах мөнгөн шагналтай байх бөгөөд дагалдах мөнгөн шагналыг Ажлын албаны тодорхойлолтыг үндэслэн тухайн байгууллагаас нь олгоно.

2.4.3. “Орхон аймгийн оны Алдартан” шагналаар тухайн онд хөдөлмөрийн өндөр амжилт гаргаж, амжилт бүтээлээрээ салбартаа хошуучилсан хүнийг тухайн оны ажлын үр дүнг харгалзан оны эцэст шагнана

2.4.3.1. “Орхон аймгийн оны Алдартан” шагнал нь Өргөмжлөл, 100.000 төгрөгийн дагалдах мөнгөн шагналтай байх бөгөөд тухайн хүнийг Аймгийн ИТХ-ын Хүндэт самбарт зургийг нь тавьж алдаршуулна.

2.4.4. Аймгийн ИТХ-ын “Хүндэт жуух бичиг”-ээр тус аймгийн бүтээн байгуулалтад 5 ба түүнээс дээш жил ажиллаж ажлын амжилт гаргасан хүнийг шагнах бөгөөд дагалдах мөнгөн шагнал нь 50.000 төгрөг байна.

2.4.4.2. Аймгийн ИТХ-ын “Хүндэт жуух бичиг”-ээр ажлын үр дүнг харгалзан тухай бүр шагнана.

Гурав. Аймгийн ИТХ-ын шагналд тодорхойлох

3.1. Аймгийн ИТХ-ын шагналаар шагнуулах тухай тодорхойлолтыг тухайн байгууллага, хамт олон гаргана.

3.2. Хэрэв урьд нь Аймгийн ИТХ-ын шагналаар шагнуулсан бол түүнээс хойш гаргасан ажлын амжилт, бүтээлийг тодорхой дурдна.

3.3. “Орхон аймгийн оны Алдартан” шагналд тухайн жилийн ажлын үр дүнг харгалзан шинэ жилийн баярыг тохиолдуулан аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчид, аймгийн Засаг даргын Тамгын газрын хэлтсүүд, байгууллага, аж ахуйн нэгжүүд нэр дэвшүүлнэ.

3.4.Аймгийн ИТХ-ын бусад шагналд Багийн тодорхойлсон материалыг Сум,бусад салбарын хувьд Аймгийн Засаг даргын Тамгын газрын хэлтэс, холбогдох дээд шатны байгууллагаар дамжуулан ирүүлнэ.

Дөрөв. Шагналын тодорхойлолтыг хүлээн авах, шийдвэрлэх

4.1.Шагналд тодорхойлсон материалыг аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн Ажлын алба хүлээн авч, Хурлын даргад танилцуулах бөгөөд материал хүлээн авснаас хойш 1 сарын дотор багцлан шийдвэрлэнэ.

4.2.Аймгийн ИТХ-ын шагнал “Цагаан арслан” цом, “Орхон аймгийн оны Алдартан” шагналыг Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн хуралдаанаар хэлэлцэн шийдвэрлэнэ.

4.3.Аймгийн ИТХ-ын “Иргэний төлөө” медаль, “Хүндэт жуух бичиг” шагналаар шагнах асуудлыг Аймгийн ИТХ-ын дарга шийдвэрлэнэ.

4.4.Аймгийн ИТХ-ын шагналыг Аймгийн ИТХ-ын даргын албан тасалгаа болон Хүндэтгэлийн өргөөнд гардуулна. Уг шагналыг аймгийн ИТХ-ын дарга, түүний эзгүйд орлож буй Тэргүүлэгч гардуулна. Аймгийн ИТХ-ын төлөөлөгч, Ажлын албаны даргын аль нэг гардуулж болно.

4.5.Шагнал гардуулах ёслолын ажиллагааг Ажлын алба хариуцан зохион байгуулж, хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчилна.

Тав. Бусад

5.1.Аймгийн ИТХ-ын шагнал болон түүний үнэмлэхийг хаяж үрэгдүүлсэн тохиолдолд холбогдох хүсэлтийг нь үндэслэн нөхөн олгоно.

-----000-----



**ОРХОН АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ**

2016 оны 10 сарын 04 өдөр

Дугаар 114

Эрдэнэт

Журамд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын үйл ажиллагааны үндсэн журмын 16.1 дэх заалтыг үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. “Аймгийн ИТХ-ын шагналын журам”-ын 2.4.2 дахь заалтын Аймгийн ИТХ-ын шагнал “Иргэний төлөө медаль”-иар тус аймагт 10-аас доошгүй жил ажиллаж ...гэснийг 15 жил, “Аймгийн ИТХ-ын шагналын дагалдах мөнгөн шагналыг Хурлын байгууллагын шийдвэр, тодорхойлсон байгууллагын саналыг тус тус үндэслэн тухайн байгууллагаас гаргуулж болно” гэж 2.5 дахь заалт болгон нэмж, тус тус өөрчлөлт оруулан баталсугай.

2. Аймгийн ИТХ-ын шагналын журманд оруулсан өөрчлөлтийг олон нийтэд мэдээлэх, мөрдөж ажиллахыг аймгийн ИТХ-ын дарга П.Пүрэвлхагвад даалгасугай.

ДАРГА  П.ПҮРЭВЛХАГВА

